

ЭД МӨНГӨНИЙ ХОНЖВОРТ СУГАЛААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Тусгай зөвшөөрөл авах, сунгахад тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт
<p>1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулиар зохицуулна.¹</p> <p>2. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.</p> <p>3. Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.</p> <p>4. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.</p> <p>5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.</p>	<p>1. Сугалааны нөхцөл буюу үйл ажиллагаа эрхлэх төсөл</p> <p>2. Хүсэлт гаргагчийн аудитаар баталгаажуулсан сүүлийн улирлын тайлан баланс</p> <p>3. Татварын өр төлбөртэй эсэх талаарх харилцагч банкны баталгаа</p> <p>4. Сугалаанаас олсон орлогыг хуваарилах норматив</p> <p>5. Сугалааны тасалбар, эсхүл сугалааны нөхцлөөр тохирсон бусад баримт бичгийн загвар, түүнд тавигдах шаардлага, түүн дээр буулгасан бичиг, зураг, эсхүл тэмдэг, сугалааны тасалбарыг дууриалган хуулбарлахаас сэргийлэх арга</p> <p>6. Сугалааны хонжворыг олгох, төлөх үед билетийг шалгах, магадлах дүрэм</p> <p>7. Сугалаа зохион явуулах техник, эдийн засгийн үндэслэл, сугалаа зохион явуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, сугалааны орлогын урьдчилсан тооцоо</p> <p>8. Сугалаа борлуулах зах зээлийн судалгаа</p> <p>9. Сугалааны тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд</p> <p>10. Тараагдсан болон тараагдаагүй сугалааны тасалбарыг бүртгэх журам</p> <p>11. Тараагдаагүй тасалбарыг хураан авах, хадгалах устгах журам</p> <p>12. Тодорсон ялагч нь шаардаж аваагүй хонжворыг хадгалах журам, хонжвор олгох хугацаа дууссаны дараа тэдгээрийг хүлээлгэн өгөх журам</p> <p>13. Хэрвээ эд мөнгөний хонжворт сугалааг цахим хэлбэрээр явуулах бол төсөлд энэ талаар дэлгэрэнгүй, энгийн байдлаар ойлгомжтойгоор тайлбарлаж, операторуудтай хийсэн гэрээгээ хавсаргаж ирүүлнэ.</p>	<p>1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;</p> <p>2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;</p> <p>3. тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;</p> <p>4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /Улаанбаатар банкны 2611178564 дугаарт дансанд тушаана/;</p> <p>5. тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг; /ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ-д заасан баримт бичгүүд/</p>

ТӨСВИЙН ОРЛОГЫН ХЭЛТЭС ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР САНГИЙН ЯАМ

¹ Тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотойгоор гаргасан Сангийн сайдын 2006 оны 12 дугаар сарын 25-ны 434 тоот тушаалыг хүчингүй болгосон тул холбогдох журмыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.1, 15.4.4-т заасныг үндэслэн зохицуулна.